

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН
ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ
АКТЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГ. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРААНГУЙ

ХОЁР. НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

ГУРАВ. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН
ШИНЖИЛГЭЭ

ДӨРӨВ. ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ ХӨНДӨГДӨХ ЭСЭХИЙГ ҮНЭЛСЭН
БАЙДАЛ

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НЭГ.ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН НӨЛӨӨЛЛИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ:

ҮНДЭСЛЭЛ,
ШААРДЛАГА,
ЗОРИЛТ

ҮНДЭСЛЭЛ:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад дараах өөрчлөлтийг оруулах:

- 1.1. 2.2. “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 100,000 төгрөг” гэснийг “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 70,000 төгрөг” гэж;
- 1.2. 2.3. “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 130,000 төгрөг” гэснийг “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 90,000 төгрөг” гэж;
- 1.3. 2.6. “Хүнсний зах” 150,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэснийг “Хүнсний зах” 200,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэж;
- 1.4. 2.7. “Барааны зах” 150,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэснийг “Барааны зах” 200,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэж;
- 1.5. 2.8 “Их дэлгүүр 2,000,000 төгрөг” гэснийг “Их дэлгүүр 200,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэж;

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 6.3 “Банк, Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэсний “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэснийг хасах;

3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3.1 “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр 70,000 төгрөг” гэж нэмэх.

ШААРДЛАГА:

	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах. ЗОРИЛТ: Дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах, иргэд, аж ахуйн нэгжийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах асуудлуудыг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.
ЭРХ ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨХ БҮЛГИЙГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг өөрчлөн тогтоох тогтоолын төсөлд иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдээс санал авахаар дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа 8 нэрийн хүнсний дэлгүүр, хүнсний зах, барааны зах болон банк бус санхүүгийн байгууллагуудын дунд хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт нийт 124 аж ахуйн нэгж байгууллага, 270 иргэн оролцож, хог хаягдлын хураамжийн хэмжээг багасгахыг дэмжиж санал асуулгад гарын үсэг зурсан. Хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн 73 хувь нь хог хаягдлын хураамжийг 6000 төгрөг байхыг дэмжсэн бол, аж ахуйн нэгжүүдийн 65 хувь нь дүүргээс санал болгож буй өөрчлөлтийн тарифийг дэмжсэн байна.

ХОЁР. НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ:

Хог хаягдлын тухай хуулийн зорилт нь “хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад” орших бөгөөд тус хуулиар энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх эрхийн тухайн аймаг, дүүргийн ИТХ болон засаг даргад олгосон.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсгийг удирдлага болгон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалаар баталсан Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалын дагуу нөлөөллийн шинжилгээ хийгдэхээр зохицуулсан байна.

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаартай тогтоол дахь хог хаягдлын менежментийн агуулга нь “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн батлах” бөгөөд уг тогтоолоор өмнө мөрдөгдөж байсан тарифыг бууруулах зорилготой юм.

Ийнхүү шинэчлэгдэн баталсан тогтоолыг ХЗДХЯ-нд бүртгүүлж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах хэрэгцээ шаардлага урган гарсны улмаас Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх, хүчин төгөлдөр эрх зүйн акт боловсруулах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

ГУРАВ. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн актын үндэслэл, шаардлага, зорилт:

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь хэсэгт энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх бүрэн эрх нь Аймаг, дүүргийн ИТХ, засаг даргад хамаарах бөгөөд Чингэлтэй дүүргээс “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг өөрчлөн тогтоох” тогтоолын төсөлд иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдээс санал авахаар дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа 8 нэрийн хүнсний дэлгүүр, хүнсний зах, барааны зах болон банк бус санхүүгийн байгууллагуудын дунд хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт нийт 124 аж ахуйн нэгж байгууллага, 270 иргэн оролцож, хог хаягдлын хураамжийн хэмжээг багасгахыг дэмжиж санал асуулгад гарын үсэг зурсан. Хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн 73 хувь нь хог хаягдлын хураамжийг 6000 төгрөг байхыг дэмжсэн бол, аж ахуйн нэгжүүдийн 65 хувь нь дүүргээс санал болгож буй өөрчлөлтийн тарифийг дэмжсэн байна.

Дүүргийн ИТХ-аас санал болгож буй өөрчлөлтийн тариф нь үндсэндээ аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын хураамжийг бууруулах, менежментийг сайжруулахад чиглэгдсэн байх бөгөөд дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад дараах өөрчлөлтийг оруулах:

- 1.1. 2.2. “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 100,000 төгрөг” гэснийг “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 70,000 төгрөг” гэж;
- 1.2. 2.3. “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 130,000 төгрөг” гэснийг “8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 90,000 төгрөг” гэж;
- 1.3. 2.6. “Хүнсний зах” 150,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэснийг “Хүнсний зах” 200,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэж;
- 1.4. 2.7. “Барааны зах” 150,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэснийг “Барааны зах” 200,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэж;
- 1.5. 2.8 “Их дэлгүүр 2,000,000 төгрөг” гэснийг “Их дэлгүүр 200,000 төгрөг” /нэг рейсийн үнэ/ гэж;

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 6.3 “Банк, Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэсний “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэснийг хасах;

3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3.1 “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр 70,000 төгрөг” гэж нэмэх гэсэн заалтууд тус тус хамаарч байна.

Энэ нь дэлгүүр, үйлчилгээний газрын төлж буй хог хаягдлын тарифыг бүхэлд нь бууруулж, томоохон зах, худалдааны төвүүдийн хог хаягдлыг рейсээр тооцож зөөвөрлөх нь эргээд тухайн аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллгааны нөхцөл байдалд нийцсэн боломжит хувилбаар болохыг хэлэлцүүлэгт оролцогчдын саналаас баталгаажуулж болно.

Судалгаанд хамрагдаж, хэлэлцүүлэгт оролцсон аж ахуйн нэгжийн үйлчилгээ эрхлэгч иргэдийн саналаас дурдвал:

Аж, ахуй нэгжийн төлөөлөл иргэн: Ээжийн буян дэлгүүр манай дэлгүүр 2 хамтраад 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 100 мянган төгрөг болж нэмэгдүүлсэн хогны гэрээний төлбөрийн талаар анх дүүргийн удирдлагуудад хүсэлтийг удаа дараа тавьсаны үндсэн дээр өнөөдөр хогны төлбөр 70 мянган төгрөг байхаар өөрчлөлт оруулж байна. Танилцуулсан 5 асуудлаар өөрчлөлт орох юм байна гэж ойлголоо. Манайх олон жил дэлгүүр ажиллуулж байгаа бөгөөд нэг ч удаа хогоо ачуулж байгаагүй. Учир нь торны хогийг буцаагаад хэрэглэдэг, цаасан хайрцаг хогийг гэр хорооллын иргэд бараг булаацалдаад аваад явчихдаг ойр зуурын жижиг ахуйн хогийг бид өөрсдөө гэррүүгээ авч яваад тэндээ нэгтгээд ачуулдаг. Мөн сүлжээ хүнсний дэлгүүрүүд болох сю, жс-25 зэрэг хоол, хүнс гаргадаг дэлгүүрүүд хог их таридаг тул энэ дэлгүүрүүдийн үйл ажиллагааны чиглэлээс нь хамаараад хогны мөнгийг ялгамжтай тогтоох нь зүйтэй байх гэж бодож байна. Одоо хогны төлбөрийг 70 мянга болгон багасгаж байгааг дэмжиж байна.

Аж, ахуй нэгжийн төлөөлөл иргэн: Гэр хорооллын иргэд хогоо хогийн цэгт гаргаж тавихаар ачиж байгаа ажилчид болон хог ухдаг иргэд, нохой гээд гаргаж тавьсан хогийг гудамжаар нэг болгочихдог. Хогийг цаг хугацаанд нь ачуулах, зөвшөөрөгдсөн цэгт хогоо тавихгүй сул орон зайтай газар хогийг үлдээдэг асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн ухамсарт нөлөөлөх, шаардлага тавих ажлыг төрөөс хийх хэрэгтэй байна гэх зэргээр санал өгч “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг хэлэлцүүлэгт оролцогчдын 100 хувийн саналаар зөвшөөрч, шийдвэрлэсэн байна.

Ийнхүү иргэдийн төлөөллөөс санал авч хэлэлцүүлсэн нь Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалын 1.4.3 дахь хэсэгт заасан “хуульд заасан нууцад хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх”, 1.4.5 дахь хэсэгт заасан “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх” 1.4.6 дахь хэсэгт заасан “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд

тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах” гэсэн заалтуудыг бүрэн хангаж байгаа юм.

Мөн аргачлалын 1.4.1 дахь хэсэгт заасан “хуульд үндэслэх” шаардлагын хувьд энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 25 дугаар зүйлийн 25.1.14, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаал болон бусад хууль, холбогдох баримт бичгийн хүрээнд хог хаягдлын төлбөр хураамжийг өөрчлөхөөр шийдвэрлэсэн байна.

Ийнхүү Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаартай “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төсөл нь хууль тогтоомж болон бусад холбогдох эрх зүйн хэм хэмжээний актуудад нийцсэн шийдвэр болж байна.

Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаартай “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол нь Тэргүү, Үндэслэл, Тогтоох /6 зүйл/ хэсэг, хавсралтаас бүрдэнэ.

ТЭРГҮҮ:

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 25 дугаар зүйлийн 25.1.14, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаал болон бусад хууль, холбогдох баримт бичгийг тус тус үндэслэн боловсруулсан.

ТОГТООХ ХЭСЭГ:

1 Дүүргийн ИТХ-ын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад зохих өөрчлөлтүүдийг оруулахаар;

2 Дүүргийн ИТХ-ын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3 дахь хэсэгт мөн өөрчлөлт оруулахаар;

- 3 Дүүргийн ИТХ-ын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3.1 дэх хэсэгт мөн өөрчлөлт оруулахаар тус тус тогтоож,
- 4 Тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх, сурталчлах таниулах, дагаж мөрдүүлэх тогтоолын хэрэгжилтийг хангахыг дүүргийн Засаг даргад үүрэг болгосон.
- 5 Дүүргийн ИТХ-ын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын зарим хэсгийг хүчингй болсонд тооцсон.
- 6 Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар ИТХ-д үүрэг болгосон.

ХАВСРАЛТ:

“Чингэлтэй дүүргийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай захиргааны хэм хэмжээний актын нөлөөллийн шинжилгээний тайлан”-г хавсаргав.

ДӨРӨВ. ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ ХӨНДӨГДӨХ ЭСЭХИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тогтоолын төслийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг судалгаанд хамруулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Захиргааны хэм хэмжээний актын төслийн зохицуулалт нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж байна. Тогтоолын төсөл нь өрсөлдөөнийг хязгаарласан, бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авилга гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэхийг ерөнхий асуултуудад хариулах замаар тодорхойлсон бөгөөд нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөны хувьд тохирох шаардлагуудыг бүрэн хангаж байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс холбогдох судалгаа, мэдээлэлд үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолыг холбогдох хуульд заасны дагуу “Улсын нэгдсэн бүртгэл”-д 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 1/87 дугаартай албан бичгээр хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд 6587 дугаарт бүртгүүлж баталгаажуулсан. Тус тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өөрчлөлт оруулах саналыг хүлээн авч тодорхой тооцоо, судалгааг хийсний үндсэн дээр тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн саналын дагуу бусад дүүрэгт хэрэгжиж буй тогтоолын

хүрээнд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг харьцуулан судалж үзвэл дараах харьцуулалт харагдаж байна.

Төрөл	Сонгинохайрхан дүүрэг	Баянзүрх дүүрэг	Чингэлтэй дүүрэг
8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк ² хүртэл/	40,000	50,000	100,000
8 нэрийн дэлгүүр хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк ² хүртэл болон Супермаркет/	60,000	65,000	130,000
Хүнсний зах /нэг рейсийн үнэ/	150,000		150,000
Барааны зах/нэг рейсийн үнэ/	150,000		200,000

Үүнээс харвал энгийн хог хаягдлын хураамжийг тогтоохдоо талбайн хэмжээг ойролцоо авч үзэн тогтоосон дүүргүүдийн хувьд Чингэлтэй дүүрэгт тогтоосон үнийн тарифаас даруй бага үнийн дүнтэй байна. Энэ нь хэт өндөр тогтоосон үнийн дүнг бууруулах шаардлагатай талаар ирүүлсэн саналд нийцэж байгаа юм.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 25 дугаар зүйлийн 25.1.14, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаал болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.